

“ХОТГОЙДЫН УНАГА” ХЭМЭЭХ АРДЫН ДУУНЫ ТУХАЙД

Ж.Болдбаатар

Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн: “Ая нь аргадаж, үг нь зэмлэсэн ардын дуу” гэж тун ончтой тодорхойлжээ. Манай монголчууд дууч, хөгжимлөг ард түмэн. Дуу болгон намтар, түүхтэй. Ялангуяа ардын дуу бол үгийн хувьд хэлэндээ ширгээж, ухаандаа богшоосон, ая дангийн тухайд сэтгэлийнхээ гүнээс хөглөж, цаг цагийн уянгын түрлэг нэмсэн ардын гүн ухааны тайлал байдаг. Ардын домогт дуу олон. Домог бол уянгын халилаар жигүүрлэсэн түүхэн үнэн юм. 1970-аад онд Булган аймгийн соёлын ордонд Шагжаа хэмээх ардын уртын дууч хүн ажиллаж байлаа. Тэрхүү авъяаслаг хүнтэй аян замын учрал таарч, дуулж хуучилж яваад “Хотгойдын унага” хэмээх ардын дууны домгийн нэгэн хувилбарыг сонсож билээ. Эл дуу олон арван бадагтай, нутаг нутагт янз бүрийн үг, ая донжоор дуулдаг, домгийн хэд хэдэн хувилбартай.

Хотгойдод наадам бүхний түрүү магнай авдаг хонгор халзан хүлэгтэй нэгэн эгэл ард байжээ. Хонгор халзан олон ч наадамд түрүүлж, эзнээ баярлуулан, аньсага норгож, самсаа шархируулдаг байсан гэнэ. “Хүн эцэж, хүлэг харьдаг” нь жам ёсон. Хурдан хөлөг өтөлжээ. Нэгэн өдөр хонгор халзан морины эзнийг хошуу ноён дуудуулжээ. Дуудсан ёсоор ноёнд бараалхахад:

- Чиний хүрэн халзан хол, ойрын олон наадамд түрүүлж, нутаг усныхаа нэрийг алдаршууллаа хэмээн магтжээ. Ноёны шадар түшмэл:

- Манай нутаг ийм хурдан хүлгийн угшил тасрахгүй байх бэлэг дэмбэрэлийг бодож, хүлэг хөгширсөн ч түүнийг ноёны торгон сүрэгт нийлүүлбэл яасан бэ? гэж чамайг дуудсан гэв. Морины эзэн:

- Ерөөлөөр болог. Өдрийн сайныг сонгон байж, ноёнтон танд хонгор халзан морио өргөн баръя гэжээ.

Чингээд өдрийн сайныг шилж сонгон, ноёндоо хайртай хүлэгээ өргөхдөө ингэж дуулсан юм гэдэг.

Хотгойдын унага

Хонгор халзан морь минь

Хорин таван насандаа

Хойх нь цолыг дуудуулжээ хэмээн морио хөгширч харьсаныг хэлээд, ид уралдаж, хурдалж, түрүүлж явсныг нь магтаж:

Унаган насаа уяулаад
Дааган насаа давхиулаад
Долоон хошуу даншигтаа
Даамай хурдан түрүүлжээ
 Хаад хаадын үүдэн дээр
 Хазаар даран тэмүүлнэ
 Хазаарлаад ирсэн жаалуудаа
 Харан харан ажина
Эзэд, эздийн үүдэн дээр
Эмээлтэйгээ дүүхэлзэнэ
Эмээллээд ирсэн жаалуудаа
Эргэн эргэн харна хэмээн дуулжээ.

Дараа нь унаж эдэлж, амь амьжиргаагаа залгуулахад хичнээн тустай байсныг нь дурсан:

Хад ихтэй газар
Хальтарч үзээгүй морь юм
Халиу, булга хоёрыг
Гаргааж үзээгүй морь юм
 Үлий ихтэй газар
 Бүдэрч үзээгүй морь юм
 Үнэг, чоно хоёрыг
 Гаргааж үзээгүй морь юм хэмээн аялсан гэдэг.

Мориныхоо цулбуурыг эзэн ноёндоо гардуулахын өмнө:

Алтан, алтан зуузайгий нь
Аяыг нь дагуулж татаарай
Алтан сайхан зоогий нь
Аяар аяар гуядаарай
 Мөнгөн, мөнгөн зуузайг нь
 Мөрийг нь дагуулж татаарай
 Мөлгөр хөөрхөн хондлойг нь

Аяар аяар гуядаарай хэмээн хайр, уярал хослуулан нулимсаа арчин, арчин байж өргөсөн гэдэг. Тэр цагаас Хотгойдын хурдан хүлгийн удам угшил улам сайжирч, зуун зууныг дамжин хонгор халзангийн төвөргөөн үргэлжлэн буй гэнэ.